

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**


/2024 оны хагас жилийн байдлаар/

2024.06.05

Эрдэнэт хот

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)			Хэрэгжүүлэх байгууллага			Биелэлт	Тухайн жилийн үнэлгээ /хувь/	
							2024 он			Үндсэн	Хамтрагч	Оролцогч			
							Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл						
<b>ЭРҮҮЛ ХҮНС</b>															
134	4.2. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана.	1	“Эрүүл Хүнс-Эрүүл Монгол Хүн” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж хүн амын хүнсний хэрэгцээт мах, төмс, гурилыг бүрэн, хүнсний ногооны 50-аас доошгүй хувийг орон нутгийн үйлдвэрлэлээс хангах	2021 - 2024	Орон нутгийн төсөв	75.0	Хэрэгжилтийн хувь 30%	Хэрэгжилтийн хувь 70%	25.0		ХХААГ ХОХБ ТХ	МХГ ЭМГ Сумын ЗДТГ СХЗХ	Хувийн хэвшил	Аймгийн хэмжээнд эхний хагас жилийн байдлаар хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа нийт 55 үйлдвэрийн 13 нь буюу 23.0 хувь баталгаажуултад хамрагдаж 14 нэр төрлийн 202 нэрийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийн тохирлын гэрчилгээ олгож тендерт өрсөлдөхөд нь болон үйлдвэрлэлээ өргөтгөж зээл тусламжид хамрагдахад нь дэмжлэг үзүүллээ. Үүнээс хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг явуулж байгаа 17 үйлдвэрээс 11 нь буюу 64.7 хувь баталгаажуултад хамрагдаж 56 нэрийн бүтээгдэхүүн тохирлын баталгаатайгаар зах зээлд нийлүүлэгдэж байна.	70%


138	4.3. Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана.	2	Хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартын талаар үйлдвэрлэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх	2022 - 2024	Орон нутгийн төсөв	6.0	20 үйлдвэрлэл эрхлэгч	20 үйлдвэрлэл эрхлэгч	2.0 сая төгрөг	1,0 сая төгрөг	СХЗХ ХОХБ ТХ	-	ААНБ	<p>Орхон аймгийн хүнсний чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Хүнсний худалдаа, үйлчилгээ, хоол үйлдвэрлэлд зохистой дадлыг хэвшүүлэх, хүнсний үйлдвэрлэлд Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг шинжлэн хянах тогтолцоо (НАССР) болон Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын 2024 оны “Стандарт хэрэгжүүлэх тухай” А/353 тоот захирамж гарч хэрэгжиж байна. Захирамжыг хэрэгжүүлэхээр хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдээс 5 үйлдвэр сонгон авч дээрх 2 тогтолцооны стандартыг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг танилцуулах уулзалт арга хэмжээг 5-р сарын 30-ны өдөр зохион байгуулж, удирдлагуудтай нь саналаа солилцож, амлалт авлаа.</p> <p>Хүнсний худалдаа, үйлчилгээ, хоол үйлдвэрлэлд зохистой дадлыг хэвшүүлэх зорилгоор “Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн (GMP, GHP) зохистой дадлыг хэвшүүлэх нь” сэдэвт сургалтыг 218 аж ахуйн нэгж, байгууллагын 280 хүнд зохион байгууллаа. Үүнээс: хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 21 аж ахуйн нэгж оролцлоо</p>	90%
-----	--	---	--	-------------	--------------------	-----	-----------------------	-----------------------	----------------	----------------	--------------	---	------	---	-----


																			
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	---	--

139		Тохирлыг илэрхийлэх чанар, аюулгүй байдлын тэмдэгтэй бүтээгдэхүүн бий болгох замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх	2022 - 2024	Орон нутгийн төсөв	9.0	Чанар, аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний эзлэх хувь 0%	Чанар, аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний эзлэх хувь 5%	3.0		CX3X	ХОХБ ТХ ХХААГ	ХАҮТ	<p>2024 оны байдлаар талх, нарийн боовны 2, мал төхөөрөх болон мах боловсруулах 2, оёмол, сүлжмэл, нэхмэлийн 1 үйлдвэрийн нийт 5 үйлдвэрийн 12 нэр төрлийн 148 нэрийн бүтээгдэхүүнд "Баталгаажсан бүтээгдэхүүн" тэмдгийг хэрэглэх эрх олгосон нь нийт үйлдвэрлэлийн 11 хувийг эзэлж байна.</p> <p>Засгийн газраас батласан "Техникийн зохицуулалт"-ын шаардлагыг хангаж аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх үүрэг бүхий мал төхөөрөх, боловсруулах 3, мах, махан бүтээгдэхүүний 6, сүүний 2, бялуун бүтээгдэхүүний 6, нийт 17 иргэн, аж ахуйн нэгжийн цех, үйлдвэр байгаагаас тохирлын үнэлгээнд хамрагдсан "Жүр үр" ХХК аюулгүйн тэмдгийг 12 нэрийн бялуун бүтээгдэхүүнд хэрэглэх эрх авч, нийт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн 5.8 хувь нь аюулгүйн тэмдэгтэйгээр зах зээлд нийлүүлэгдэж байна.</p> <p>Энэ онд "Эрдэнэт мах маркет" ХХК-ны мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрийн аюулгүйн тэмдэг авах хүсэлтийн дагуу үнэлгээнд хамруулж, холбогдох шаардлагыг хангах үүрэг даалгавар өгч, сайжруулалт хийлгэж байна.</p> <p>Аюулгүйн тэмдгийн талаар мэдлэг ойлголтыг 161 хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдэд өгч, мэдээллийн самбарт нь зурагт хуудсаар байршуулах, орон нутгийн</p>	90%
-----	--	---	-------------	--------------------	-----	--	--	-----	--	------	---------------	------	---	-----



													хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр түгээх зэргээр нийтэд сурталчилсан. Нээлттэй хаалганы өдөрлөгийг Жаргалант суманд болон Зэст, Эрдэнэ, Чингэл, Яргуйт, Баян-Овоот, Даваат, Шанд, Говил, Баянцагаан багуудад зохион байгуулж, танилцуулга самбар бэлтгэн иргэдэд сурталчилж тэдний бүтээгдэхүүний сонголтод дэмжлэг үзүүлж байна.		
140		4	Хүнсний аюулгүй байдлыг хангах (НАССР) болон ISO:22000 стандартыг үйлдвэрүүдэд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2022 - 2024	Орон нутгийн төсөв	7.5	Хамрагдсан үйлдвэрийн тоо 5	Хамрагдсан үйлдвэрийн тоо 10	2,5	5,2 сая	СХЗХ ХОХБ ТХ	Хамтарсан багууд	-	Аймгийн хэмжээнд Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO 22000:2019 стандартыг хэрэгжүүлж гэрчилгээжсэн 3 аж ахуйн нэгж Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (НАССР) буюу MNS HAC /RCP 1:2003 стандартыг хэрэгжүүлэн гэрчилгээжсэн мал төхөөрөх, мах боловсруулах 3 үйлдвэр байна Аймгийн Засаг даргын 2024 оны А/353 тоот захирамжийн дагуу хүнсний боловсруулах 4 үйлдвэрлэлд Аюулын дүн шинжилгээ болон эгзэгтэй цэгийн тогтолцоо /НАССР /-г, талх нарийн боовны 1 үйлдвэрлэлд Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO:22000 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэн, уулзалт, сургалт зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.	90%
ЗУРГАА.АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО															
7.2.Эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.															

203	7.2.2. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлнэ.	2	Ахуйн үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтийн түвшин дээшлүүлэхэд сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж, тохирлын үнэлгээнд хамруулах	2022 - 2024	Орон нутгийн төсөв	6.0	Шаардлага хангасан үйлчилгэний хувь 20%	Жил бүр 10%	2,0	-	СХЗХ	ХХААГ Аймгийн ЗДТГ	-	<p>Ахуйн үйлчилгээний чиглэлээр халуун ус, саун, үсчин, гоо сайхны 68 цэг тогтвортой ажиллаж байна.</p> <p>Ахуйн үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтийн түвшин дээшлүүлэхэд Засгийн газрын 2018 оны 291-р тогтоолоор батлагдсан заавал тохирлын баталгаажуулалтад хамрагдах үйлчилгээний талаар нийт 3 удаагийн мэдээлэл сурталчилгааг зохион байгуулж халуун ус, саун, үсчин, гоо сайхны үйлчилгээ эрхлэгчдийг хамруулснаар энэ онд 2 аж ахуйн нэгж, 1 иргэний 3 нэр төрлийн 6 үйлчилгээ, сауны 3, үсчин, гоо сайхны 2, чийрэгжүүлэх 1 үйлчилгээг баталгаажуулан гэрчилгээ олгосон нь тохирлын гэрчилгээтэй үйлчилгээ 2024 онд 8,8 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс "ШИМ ГРОУ" ХХК-ны Чарминг төвийн саун, гоо сайхан, чийрэгжүүлэлтийн төв зэрэг үйлчилгээний стандартын хэрэгжилт 90-с дээш хувь хангасан тул "Баталгаажсан үйлчилгээ" тэмдэг хэрэглэх эрх олгосон байна</p> 	90 %
-----	---	---	--	-------------	--------------------	-----	---	-------------	-----	---	------	--------------------	---	--	------

207	7.2.4. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.	2	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд тохирлын баталгаажуулалтаар дэмжлэг үзүүлэх	2022-2024	Улсын төсөв Орон нутгийн төсөв	20.0	Нийт үйлдвэрлэлийн 20%	Нийт үйлдвэрлэлийн 40%	5.0	-	СХЗХ	ХХААГ МХГ	-	<p>Аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа мал төхөөрөх 3, мах, махан бүтээгдэхүүний 8, сүүний 3, гурил, тэжээлийн 4, ноос ноолуурын 4, арьс ширэн бүтээгдэхүүний 2, нийт 24 үйлдвэр ажиллаж байна. Үүнээс 2024 онд Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 1, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэгч 5, ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 2 нийт 8 аж ахуйн нэгжийн хүсэлтээр 14 нэр төрлийн 128 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгон, бүтээгдэхүүнээ тохирлын баталгаатайгаар хэрэглэгчдэд нийлүүлэх, тендерт өрсөлдөхөд болон гадаад оронд экспортлоход нь дэмжлэг үзүүлээ.</p> <p>Нийт үйлдвэрлэлийн 35,2 % баталгаажуултад хамрагдсан байна. Эрдэнэт хивс, ХХК-ны үйлдвэрлэж экспортод гаргадаг 3 нэрийн бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгосон, Эрдэнэт кашмер ХХК-ны 3 нэр төрлийн 40 нэрийн бүтээгдэхүүнд "Баталгаажсан тэмдэг" олгож бүтээгдэхүүнээ тохирлын баталгаатайгаар хэрэглэгчдэд нийлүүлэх, тендерт өрсөлдөх, экспортод гаргахад нь дэмжлэг үзүүлсэн</p> <p>Нийт 8 үйлдвэр гадаад экспортыг хийж байна. Тус үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний экспортод гаргах тухай бүрийд нь тохирлын баталгаажуулалтад хамруулан гэрчилгээжүүлж, гадаад худалдааг хөнгөвчиллөө. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 35,2% нь гадаад экспорт хийж байна.</p> 	90%
Дүн														86,7%	

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ**

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН / хагас жилээр /**

2024-06-10

Эрдэнэт хот

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Хариуцах байгууллага	Хэрэгжилтийн хувь
				2024 он	2024 он			
95	Сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүнс үйлдвэрлэгчдийн тоо	Хувь	20%	20%	18%	Хүнсний үйлдвэрийн - 10 Хоол үйлдвэрлэлийн - 43	СХЗХ	100%
96	Аюулгүй байдлын тэмдэгтэй бүтээгдэхүүний тоо	Тоо	5%	5%	5,8%	Техникийн зохицуулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс Аюулгүйн тэмдэгтэй 1 үйлдвэрийн 12 бүтээгдэхүүн буюу 5,8%	СХЗХ	100%
97	ISO:22000 стандарт нэвтрүүлсэн үйлдвэрийн тоо	Хувь	5.4%	20%	23%	НАССР – 7 MNS ISO 22000-7	СХЗХ	70%
133	Ахуйн үйлчилгээний чанар, стандартын тохирлын гэрчилгээжилтийн түвшин	Хувь	Шаардлага хангасан үйлчилгээн ний хувь 20%	50	30%	Нийт – 68 үйлчилгээнээс 20 үйлчилгээ эрхлэгч тохирлын гэрчилгээ авсан байна Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хянах хяналтын тогтолцоо байхгүй, хэрэглэгч шаарддаггүй зэрэг нь ахуйн үйлчилгээний чиглэлийн үйл ажиллагаанд тохирлын гэрчилгээ авах сэдлийг төрүүлдэггүй, баталгаажуулалтын мэдэгдлийг үл ойшоох хандлага гаргадаг тул энэ арга хэмжээ хангалтгүй хэрэгжиж байна.	СХЗХ	40%



ДОЛОО.ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
7.1.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.								
137	Экспортод гарсан тохирлын баталгаатай бүтээгдэхүүний хэмжээ	Хувь	20	35	33	Махны 3 үйлдвэрийн 2 нэр төрлийн бүтээгдэхүүн Малын гаралтай ноос ноолууран бүтээгдэхүүний 2 үйлдвэр 4 нэр төрлийн 14 нэрийн бүтээгдэхүүн	СХЗХ	90%
							<b>Нийт</b>	<b>80.0%</b>

ХЭРЭГЖИЛТТЭЙ ТАНИЛЦСАН: СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

С.ЧУЛУУНБАТ

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН: СОРЬЦЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ БӨГӨӨД

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.БААСАНБИЛЭГТ

ХЭРЭГЖИЛТИЙГ НЭГТГЭСЭН: БҮТЭЭГДЭХҮҮН БАТАЛГААЖУУЛАЛТЫН

МЭРГЭЖИЛТЭН

О.БУЯНХИШИГ

